

ХЯТАД, МОНГОЛЫН ХИЛИЙН ДЭГЛЭМ, ХИЛИЙН
АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БАЙХ ТУХАЙ БҮГД
НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНДЫН
Г Э Р Э Э

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар,

Хоёр улсын хилийг тогтвортой, хил орчмын нутаг дэвсгэрийг амгалан тайван байлгахын тулд хоёр тал хилийн дэглэмийг хүндэтгэн сахих, харилцан ойлголцох, хамтран ажиллах үзэл санааны дагуу хилийн асуудлыг зохицуулж байх эрх зүйн үндсийг өргөтгөх зорилгоор,

Хятад, Монголын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын хоорондын Гэрээ байгуулахаар шийдвэрлэж,

дор дурдсан зүйлсийг тохиролцов:

I БҮЛЭГ

ХИЛИЙН ШУГАМЫН ЗҮГ ЧАГ, БАЙРШИЛТ
БОЛОН ХИЛИЙН ТЭМДЭГ, ТУСЛАХ ЧАНА-
РЫН ТЭМДЭГ, ХИЛИЙН ШУГАМЫН ТАНИХ
ТЭМДҮҮДИЙГ АРЧЛАН ХАМГААЛАХ

Нэгдүгээр зүйл

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хил хоёр улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг зааглан тогтоосон шугамаар болон уг шугамаас босоо гадаргаар агаарын зайд, мөн шугамаас газрын гүн уруу эгц доошоо орших шугамаар тодорхойлогдоно.

Хоёрдугаар зүйл

Хоёр улсын хилийн шугамын зүг чиг, байршилт болон хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг, хилийн шугамын таних тэмдгүүдийг дор дурдсан баримт бичгүүдийг үндэслэн арчлан хамгаална:

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улс ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1962 оны арван хоёрдугаар сарын 26-ны өдрийн хилийн Гэрээ;

2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хоёр улсын хилийн тухай 1964 оны зургадугаар сарын 30-ны өдрийн Протокол /цаашид хилийн тухай 1964 оны Протокол гэнэ/;

3. Хятад, Монголын хилийг нэг дэх удаа хамтран шалгасан тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хоорондын 1984 оны долдугаар сарын 19-ний өдрийн Протокол /цаашид хилийг хамтран шалгасан 1984 оны Протокол гэнэ/;

4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн зурвасын 1984 оны газрын зургийн альбом;

5. Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн тэмдэг, туслах чанарын тэмдгүүдийн координатын 1984 оны жагсаалт;

6. Хоёр улсын засгийн газар хилийн асуудлаар цаашид байгуулах баримт бичиг, газрын зураг.

Гуравдугаар зүйл

БНХАУ, БНМАУ-ын хилийн шугамын зүг чиг, байршилт болон хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг, хилийн шугамын таних

тэмдгүүдийн байршилтыг газар дээр нь тодорхойлохдоо хилийг хамтран шалгасан 1984 оны Протоколын хоёрдугаар бүлэгт дурдсан тодорхойлолт, Бүгд Найрамдах Хятад Ард Улс ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн зурвасын 1984 оны газрын зургийн альбом, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн тэмдэг, туслах чанарын тэмдгүүдийн координатын 1984 оны жагсаалт болон хоёр улсын засгийн газрын хооронд хилийн асуудлаар цаашид байгуулах баримт бичиг, газрын зургийг үндэс болгоно.

Дөрөвдүгээр зүйл

Хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг, хилийн шугамын таних тэмдэг, хил болгосон зам, ойн огтолсон зурвасыг арчлан хамгаалахдаа хоёр тал дор дурдсан үүрэг хүлээнэ:

1.Хилийн тэмдгийн дангаар буюу ижил дугаартай хосоор ба гурваар босгосон баганууд аль талын нутагт байна түүнийг тэр тал, хилийн шугам дээр байгаа сондгой тоогоор дугаарлагдсаныг хятадын тал, тэгш тоогоор дугаарлагдсаныг монголын тал тус тус хариуцна.

2.Хилийн ижил дугаартай хосоор босгосон туслах чанарын тэмдгийн багана аль талын нутагт байна түүнийг тэр тал хариуцна. Хилийн сондгой дугаартай тэмдэгт хамаарагдах дангаар босгосон туслах чанарын тэмдгийг хятадын тал, хилийн тэгш дугаартай тэмдэгт хамаарагдах дангаар босгосон туслах чанарын тэмдгийг монголын тал хариуцна.

Хилийн шугамын таних тэмдгүүдийг энэ зүйлд заасан журмын дагуу эрхлэн хариуцна.

3.Хилийн тэмдэг, туслах чанарын тэмдгийн холбоосыг нутаг дэвсгэрт нь байгаа тал хариуцна.Хилийн шугам дээр байгаа холбоосыг хоёр тал хамтран хариуцна.

4.Хилийн тэмдгийн төрийн сүлдтэй баганыг хоёр тал хамтран хариуцна.

5.Хил болгосон зам, хилийн шугам дээрх ойн огтолсон зурвасыг хоёр тал хамтран хариуцна.

Тавдугаар зүйл

1.Хоёр тал хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг, тэдгээрийн холбоос, хилийн шугамын таних тэмдгүүдийг арчлан хамгаалж, хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг, тэдгээрийн холбоос, хилийн шугамын таних тэмдгүүдийг хөдөлгөж шилжүүлэх, устгахаас сэргийлэх шаардлагатай арга хэмжээ авч байна.

Хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг болон хилийн шугамын таних тэмдгийг эвдэж гэмтээсэн, хөдөлгөж шилжүүлсэн, устсаныг аль нэг тал илрүүлбэл нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх бөгөөд уг тэмдгийг хариуцах тал нөгөө талынхаа хилийн ажилтныг байлцуулан хуучин байран дээр нь сэлбэн засах, сэргээх буюу шинээр босгоно.Нэг тал сэлбэн засах, сэргээх буюу шинээр босгох ажил хийхдээ 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

Харин эвдэж гэмтээсэн, хөдөлгөж шилжүүлсэн, устсан хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг болон хилийн шугамын таних тэмдгийг хуучин байранд нь сэлбэн засах, сэргээх буюу шинээр босгох боломжгүй бол хилийн шугамыг өөрчлөхгүй байх зарчмаар хоёр тал зөвлөлдөн сонгон авсан тохиромжтой цэгт тэдгээрийг босгож, энэ талаар баримт бичиг үйлдэн гарын үсэг зурна.Тэрхүү баримт бичиг нь хилийн тухай 1964 оны Протокол, хилийг хамтран шалгасан 1984 оны Протоколын хавсралт болж, дараачийн хамтарсан шалгалтын баримт бичигт тэмдэглэгдэх болно.

2.Хилийн шугам дээрх ойн огтолсон зурваст мод ургаж хилийн шугамыг ялган танихад нөлөөлбөл хоёр тал зөвлөлдөн нөгөө талынхаа хүмүүсийг газар дээр нь байлцуулан хилийн шугамын

доторх модыг өөрсдөө, хилийн шугам дээрх модыг хоёр тал хамтран огтолж, цэвэрлэж байна.

3.Аль нэг тал дангаараа хилийн шугам дээр шинэ тэмдэг босгож үл болно.

4.Хилийн шугамыг хамгаалахын тулд хоёр талын зөвшөөрөлгүйгээр хилийн шугамаас хоёр тийш тус бүр 20 метр зурвасын дотор газар хагалах, суваг шүүдүү татах, шинээр барилга байгууламж барихыг хоригдоно.Энэ заалт нь хилийн шугамыг хамгаалах зориулалттай барилга байгууламжид үл хамаарна.

II БҮЛЭГ

ХИЛИЙГ ХАМТРАН ШАЛГАХ

Зургадугаар зүйл

1.Хоёр тал хилийн тухай 1964 оны Протоколын дөчдүгээр зүйлийн заалтыг баримтлан хилийг хамтран шалгах бөгөөд хоёр улсын хилийн нийт шугамын дагуу буюу зарим хэсэгт хамтарсан шалгалт хийхтэй холбогдсон асуудлыг дипломат шугамаар тохиролцоно.

2.Хамтарсан шалгалт хийх бүрт хоёр тал хилийг шалгах хамтарсан комисс байгуулах бөгөөд уг комисс хамтарсан шалгалтын үүрэг, зарчим, ажлын журам, арга зэргийг тогтооно.

3.Хамтарсан шалгалт бүрийн эцэст хоёр тал хэлэлцэн тохирсон асуудлаар Протокол үйлдэж гарын үсэг зурна.Уг Протокол нь 1962 оны хилийн Гэрээний хавсралт, хилийн тухай 1964 оны Протоколын нэмэлт баримт бичиг болно.

4.Талууд хилийн шугамын зүг чиг, байршилт болон хилийн тэмдэг, туслах чанарын тэмдгийн хилийн шугам дээр байгаа багана,

хилийн шугамын таних тэмдгүүд, ойн огтолсон зурваст нэг талын үзлэг хийж болно. Хэрэв хил давж үзэх шаардлага гарвал 10-аас доошгүй хоногийн өмнө тэр тухайгаа нөгөө талдаа мэдэгдэж зөвшөөрөл авсны дараа үзлэг хийнэ.

III БҮЛЭГ

ХИЛИЙН УС БОЛОН ХИЛИЙН ШУГАМЫГ
ОГТЛОН ГАРЧ БАЙГАА ТӨМӨР ЗАМ,
БУСАД ЗАМ, ХОЛБОО ХАРИЛЦААНЫ
БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАХ

Долдугаар зүйл

1. Хилийн тухай 1964 оны Протокол, хилийг хамтран шалгасан 1984 оны Протоколд заасан голуудын хил болгосон хэсэг, хилийн шугам дайран гарч байгаа нуур, тойром, горхи, булаг, худаг, шандыг энэхүү Гэрээнд "хилийн ус" гэнэ.

2. Хилийн усанд ус хэмжил зүйн ажил явуулах, хилийн усны ашиглах болон хилийн усны дэглэмтэй холбогдсон бусад асуудлыг хоёр тал эрх тэгш, харилцан ашигтай байх, оие оиеийнхээ зүй ёсны ашиг сонирхлыг харилцан хүндэтгэх зарчмын үндсэн дээр жич хэлэлцэн тохиролцоно.

3. Буйр нуур дээр хоёр талын усан тээврийн хэрэгсэл хилийн усанд хилийн шугамын өөрийн талын хэсэгт явж, зогсон зангаа хаяж болно.

Хоёр талын усан тээврийн хэрэгсэл голуудын хил болгосон хэсэгт өдрийн цагаар явах эрхтэй бөгөөд хил давах шаардлагатай бол хоёр талын хилийн төлөөлөгчид хэлэлцэн шийдвэрлэнэ.

4. Хилийн усанд хилийн шугамын өөрийн талын хэсэгт явах иргэний усан тээврийн хэрэгсэл хоёр хажуу талдаа таних тэмдэг,

дугаартай байна.Хил хамгаалах албаны усан тээврийн хэрэгсэл тухайн улсын төрийн далбаа мандуулсан байна.

5.Хоёр тал хилийн уснаас малаа усалж болно.Харин малаа нөгөө талын нутагт оруулахгүй байх үүрэгтэй.

6.Хоёр тал хилийн усыг бохирдлогоос урьдчилан сэргийлэх үүрэг хүлээнэ.

Наймдугаар зүйл

1.Хоёр тал хилийн усны урсгалыг аль болохоор хэвийн байлгавал зохино.Хил болгосон голын усны урсгалыг боох, ус оруулах, зориуд ус татаж хил болгосон голын усны хэвийн түвшинг алдагдуулах буюу урсгалын чиглэлийг еерчилж үл болно.Хоёр тал хилийн усны урсгалыг хэвийн байлгах, хилийн усны байгалийн урсгалд саад болж байгаа зүйлсийг арилгах асуудлаар шаардлагатай гэж үзвэл зөвлөлдөж байна.

2.Хоёр тал хил болгосон голын усны голдрил өөрчлөгдөхийг аль болохоор сэргийлбэл зохино.Аль нэг тал нь голын эргийн шаардлагатай хэсэгт бэхэлгээ хийвал ажил эхлэхээс 3 сарын өмнө нөгөө талдаа мэдэгдэж байна.Уг ажил хил болгосон голын голдрил болон нөгөө талын эрэгт нөлөөлөхгүй байвал зохино.

Хэрэв хил болгосон голын голдрил байгалийн шалтгаанаас болж өөрчлөгдвөл хоёр тал жич хэлэлцэн зөвлөлдөх хүртэл хилийн шугам өөрчлөгдөхгүй хэвээр байна.

3.Хил болгосон гол дээр гүүр, далан, хашлага, гидротехникийн бусад байгууламжийг барих, тэдгээрийг ашиглах, өөрчлөн тоноглох, засварлах, буулгах асуудлыг хоёр тал хэлэлцэн тохирсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Есдүгээр зүйл

1. Хил болгосон замыг хоёр тал хамтран ашиглана.

2. Хилийн шугамыг огтлон гарсан төмөр зам, бусад зам, холбооны шугамыг ашиглахдаа хоёр талын эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан холбогдох хэлэлцээрүүдийг баримтална.

IV БҮЛЭГ

ХИЛ ОРЧЛЫН НУТАГТ АН АГНУУР, ҮЙЛД- БЭРЛЭЛИЙН АЖИЛ ЯВУУЛАХ, ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧИНГ ХАМГААЛАХ, ХИЛИЙН АСУУДЫГ ЗОХИЦУУЛАХ

Аравдугаар зүйл

1. Хоёр талын иргэд улсынхаа хүчин төгөлдөр байгаа хуулийн дагуу хилийн шугамын өөрийн талын хилийн усны хэсэгт загас барьж болно. Харин дараах үйлдлийг хориглоно:

а/загас агнахдаа тэсрэх, дэлбэрэх, хорт болон мансууруулах бодис хэрэглэх, загасыг олноор нь устгаж хөнөөх, түүний нэвцэд хожирол учруулж болох бусад арга хэрэглэх;

б/хилийн усанд загас болон усны бусад амьтан нүүдэллэхэд хориг саад тавих.

2. Загас, усны бусад амьтан /минж, заарт харх/-ыг хамгаалах, үржүүлэх, тэдний зарим төрлийг агнахыг хориглох, агнах хугацаа тогтоох зэрэг асуудлыг шаардлагатай бол хоёр тал жич хэлэлцэн тохиролцоно.

Арван нэгдүгээр зүйл

1. Талууд хилийн шугамаас хоёр тийш еер өөрийн нутаг дэвсгэрт 1000 метрийн бүсэд ан агнахыг хориглоно.

2.Хоёр тал ан амьтан, жигүүртнийг агнахдаа хил давуулан хөөхгүй, буудахгүй байх үүрэг хүлээнэ.

3.Хоёр тал хулан, тахь, аргаль, янгир, бөхөн, хавтгай, мазаалай, минж, булга, заарт харх гэх мэт ховордож байгаа ан амьтныг хамгаалах зорилгоор хилийн тодорхой хэсэгт дархалсан бүс бий болгох арга хэмжээг хамтран авч болно.

Арван хоёрдугаар зүйл

Хоёр тал дараах үүрэг хүлээнэ:

1.Хил орчмын нутаг дэвсгэрт хөдөө аж ахуй, ойн аж ахуй, геологи хайгуул, уул уурхайн ажил эрхлэх болон ой, ус зэрэг байгалийн баялгийг хамгаалахдаа нөгөө талынхаа эрх ашигт хохирол учруулахгүй байвал зохино.

2.Хил орчмын нутаг дэвсгэрийн газар, түүний гүн, агаар мандалд цацраг идэвхт, химийн болон бусад хорт бодис байрлуулахгүй, тархаахгүй байх.

3.Хил орчмын нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн түймрийг хил давуулахгүй байх арга хэмжээ авна.Ой, хээрийн түймэр хил давахад хүрвэл тэр тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

Хэрэв түймэр тархаж нөгөө талын нутагт орж эд материалын хохирол учруулбал хоёр талын хилийн төлөөлөгчид хохирлын хэмжээг тогтоож тус тусын эрх бүхий байгууллагад уламжилна.

4.Хүн, амьтан, ургамлын халдварт өвчин, ургамлын аливаа хортныг хил давахаас сэргийлэх арга хэмжээ авна.Хэрэв хил орчмын нутагт хүн, амьтан, ургамлын халдварт өвчний шинж тэмдэг илэрвэл нөгөө талдаа яаралтай мэдэгдвэл зохино.

Шаардлагатай бол ойн болон хөдөө аж ахуйн ургамлын өвчин, хортноос сэргийлэх асуудлаар хоёр тал тусгай хэлэлцээр байгуулж болно.

5.Хил орчмын нутаг дэвсгэрт агаараас зураг авах тухай асуудлыг дипломат шугамаар урьдчилан нөгөө талдаа мэдэгдвэл зохих бөгөөд нөгөө талынхаа хилд нэвтрэх шаардлага гарвал тэр талаасаа зөвшөөрөл авна. Дипломат шугамаар тохиролцсон зүйлсийг хоёр талын хилийн төлөөлөгчид харилцан мэдэгдэнэ.

Арван гуравдугаар зүйл

1.Талууд хил зөрчигчийн хил зөрчсөн шалтгааныг тодруулан тогтооно. Саатуулагдсан этгээд нь нэг талын хилийг санамсаргүй давсан тохиолдолд нөгөө талдаа аль болох түргэн хугацаанд шилжүүлнэ.

Хил зөрчигч, түүний тээврийн хэрэгсэл, эд юмсыг хил зөрчсөн газрыг харьяалах уулзалтын цэг буюу хоёр талын хилийн ажилтны тохиролцсон ойр газраар шилжүүлбэл зохино.

2.Хилийн ажилтан хил орчмын нутагт хил зөрчигчийн асуудлыг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Харин хил зөрчигч нь хил хамгаалагчдын эсрэг зэвсэг хэрэглэх буюу тэдний амь нас, аюулгүй байдалд заналхийлэхээс бусад тохиолдолд хоёр талын хил хамгаалагчид хил зөрчигчдөд зэвсэг хэрэглэж үл болно.

3.Хил орчмын нутаг дэвсгэрт мал, гэрийн тэжээвэр амьтныг хариулгатай байлгана. Нэг тал нөгөө талын мал, гэрийн тэжээвэр амьтан хил давж байгааг илрүүлбэл тэр чиглэлээр нь буцааж гаргана. Мал, гэрийн тэжээвэр амьтан хил давж нөгөө талын нутгийн гүнд орсон байвал богино хугацаанд эрж олох, буцааж тушаах арга хэмжээ авна.

4.Аль нэг талын хил орчмын нутагт хүний цогцос, үхсэн мал, амьтан, бусад эд юмс илэрвэл түүнийг аль талын болохыг тогтоох арга хэмжээг илрүүлсэн тал авна.

Илэрсэн кмсыг тавьж тогтооход шаардлагатай гэж үзвэл хоёр талын хилийн ажилтан нар хамтран шалгаж харьяаллыг тогтоон, хүлээлцэх асуудлыг аль болох богино хугацаанд шийдвэрлэнэ.

5.Хил давсан хүн, мал, гэрийн тэжээвэр амьтан болон бусад эд кмсыг хүлээлцэх баримт бичгийг хятад, монгол хэлээр үйлдэх бөгөөд загварыг энэхүү Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох Протоколоор тогтоов.

Ү БҮЛЭГ

ХИЛИЙН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

Арван дөрөвдүгээр ахуйл

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогчийг тус тусын засгийн газрын холбогдох байгууллагаас томилох бөгөөд зохих шугамаар харилцан мэдэгдэнэ.Хилийн төлөөлөгч хилийн асуудлыг зохицуулах ажилдаа хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/, нарийн бичгийн дарга, орчуулагч, мэргэжилтэн нарыг томилох эрхтэй.

Хилийн төлөөлөгчийн орлогч хилийн төлөөлөгчөө орлож байгаа үедээ түүний бүх эрхийг эдэлнэ.

Хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ энэхүү Гэрээний заалт болон хилийн төлөөлөгчийн даалгавраар хилийн асуудлыг зохицуулахтай холбогдсон албан үүрэг гүйцэтгэнэ.

2.Хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогч, хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/нар энэхүү Гэрээ болон хилийн холбогдолтой бусад гэрээ, хэлэлцээр,

протоколын заалтын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

3.Хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогч, хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ болон дагалдан яваа хүмүүс энэхүү Гэрээнд заасан албан үүргээ гүйцэтгэхээр нөгөө талын нутагт байхдаа халдашгүй дархан эрх эдлэх бөгөөд тэдний тээврийн хэрэгсэл, авч яваа баримт бичиг, эд кмс нь халдашгүй байна.

Аль ч тал тэднийг албан үүргээ гүйцэтгэхэд нь туслалцаа үзүүлнэ. Дээр дурдсан хүмүүс нь хүлээн авагч улсын хууль, дүрмийг хүндэтгэн сахина.

Арван тавдугаар зүйл

1.Хоёр талын хилийн төлөөлөгч хэлэлцээ хийх журмаар ажлаа явуулна.

Харин хоёр талын хилийн төлөөлөгч хэлэлцээ хийж шийдвэрлэх шаардлагагүй гэж үзсэн асуудлыг хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/-ын уулзалтаар шийдвэрлэж байна.

2.Хоёр талын хилийн төлөөлөгч энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон дор дурдсан чухал асуудлуудыг мөрдөн шалгах зохицуулна:

а/хил нэвтэрч буудсан буюу нөгөө талын нутаг уруу буудсан, түүнээс болж тэр талын нутагт хүн шархдсан, амь үрэгдсэн, эд материалын хохирол учирсан;

б/хил орчмын нутагт нөгөө талын хүнд хүч хэрэглэсэн;

в/хүн, нисэх хэрэгсэл, бусад төрлийн тээврийн хэрэгсэл хууль бусаар хил давсан, түүний улмаас болж хүрээлэн байгаа орчинд хохирол учруулсан;

г/зохиx эрх эдлээгүй хүн хууль бусаар хил давж холбоо барьсан;

д/нөгөө талын хилийн дотор эд хөрөнгө хулгайлж дээрэмдсэн, хорлон сүйтгэсэн буюу эвдэж хэмхэлсэн;

е/мал, гэрийн тэжээвэр амьтан хил давсан;

ж/түймэр тархаж нөгөө талын нутагт орсон;

з/хилийн тэмдэг, туслах чанарын тэмдэг, хилийн шугамын таних тэмдгийг эвдэж гэмтээсэн, хөдөлгөж шилжүүлсэн буюу устгасан;

и/хил орчимд гарсан аливаа хэрэг явдлын улмаас болж аль нэг талаас тавьсан талбөрийн тухай асуудал;

к/хилийн асуудлаарх хүчин төгөлдөр гэрээ, хэлэлцээр, протоколын заалтыг зөрчсөн;

л/дипломат шугамаар шийдвэрлэх шаардлагагүй хилийн бусад асуудал.

Арван зургадугаар зүйл

1.Хилийн төлөөлөгчийн албан ёсоор хариуцах хилийн хэсэг, хил нэвтрэх чиглэл, уулзалтын цэгийг энэхүү Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох Протоколоор тогтооно.Хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ нарын хариуцах хэсэг, хил нэвтрэх чиглэл, уулзалтын цэгийг хоёр талын хилийн төлөөлөгчид тохиролцоно.

2.Хоёр талын хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогч, хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ тэднийг дагалдан яваа хүмүүс энэхүү Гэрээнд

заасан албан үүргээ гүйцэтгэхээр хил нэвтрэхдээ тогтоосон загварын үнэмлэхтэй байна.Хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогчдод хил нэвтрэх үнэмлэхийг талуудын эрх бүхий байгууллага олгоно.Хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ нарийн бичгийн дарга, орчуулагч, мэргэжилтэн болон үйлчилгээний ажилтанд хил нэвтрэх үнэмлэхийг хилийн төлөөлөгч олгоно.

3.Хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогч, хилийн төлөөлөгчийн туслагч, /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ тэднийг дагалдан яваа хүмүүс хил нэвтрэхдээ хэрэглэж яваа автомашиндаа өөрийн улсын далбааг мандуулна.Морин уналгаар явахдаа зүүн гартаа таних тэмдэг зүүсэн байна.

4.Халдварт өвчин буюу бусад шалтгаанаар тогтоосон чиглэлээр хил нэвтрэхийг талуудын эрх бүхий байгууллага түр хориглож болно.Үүний улмаас хил нэвтрэх чиглэл, уулзалтын цэгийг өөрчлөх шаардлага гарвал нэг тал нь нөгөө талдаа даруй мэдэгдэнэ.Харин хил нэвтрэх шинэ чиглэл, уулзалтын шинэ цэгийг нээх хүртэл хуучин чиглэл, уулзалтын цэгийг нэг тал дангаараа хааж үл болно.

Арван долдугаар зүйл

1.Аль нэг талын хилийн төлөөлөгч хэлэлцээ хийхийг хүсвэл 5 өдрийн өмнө хэлэлцээ хийх өдөр, цаг, газар, хэлэлцэх асуудал болон оролцох хүмүүсийн бүрэлдэхүүнийг уулзалтын хэлбэрээр нөгөө талдаа мэдэгдэнэ.Тухайн тал нь ямар нэгэн шалтгаанаар санал болгосон хугацаанд хэлэлцээнд оролцож чадахгүй бол хэлэлцээ хийх хугацааг нөгөө талтайгаа шинээр товлон тогтооно.

Уулзалт хийхдээ дохиогоор буюу холбоочин илгээх хэлбэрээр холбоо барина.Уулзалтын дохио өгснөөс хойш 2 цагийн дотор,

эсвэл холбоочин холбоо барьсны дараа Э хоногийн дотор нөгөө талын уулзах хүн тогтоосон газарт хүрэлцэн очвол зохино.

Хэлэлцээ болон уулзалтыг хэлэлцээ, уулзалт хийхийг санаачилсан талд, эсвэл хоёр талын хэлэлцэн тохирсон өөр газарт хийнэ.

2.Хэлэлцээ, уулзалт бүрийн тэмдэглэлийг тус тусдаа хөтөлж, хэлэлцэн тохирсон чухал зүйлээр хамтарсан Протоколыг хятад, монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж хоёр талын хилийн төлөөлөгч буюу хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга/ гарын үсэг зурна.

Хоёр тал дараагийн хэлэлцээ болон уулзалтын үед Протоколын заалтыг хэрэгжүүлэхийн тулд авч явуулсан арга хэмжээ, үр дүнг харилцан мэдээлнэ.

Арван наймдугаар зүйл

1.Хоёр талын хилийн төлөөлөгчдийн шийдвэрлэж чадаагүй асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

2.Дипломат шугамаар ярилцсан асуудлыг хилийн төлөөлөгчдөд эгүүлж шилжүүлэн дахин хэлэлцүүлж шийдвэрлүүлэх боломжийг энэ зүйлийн I-ийн заалт үгүйсгэхгүй.

Арван есдүгээр зүйл

Хоёр талын боомтуудын холбогдох байгууллагуудын хэлэлцээ, уулзалт одоогийн мөрдөгдөж байгаа журмаар явагдана.

Хил нэвтрэх боомтыг шинээр нээх шаардлага гэрвал хоёр тал жич зөвлөлдөнө.

ҮІ БҮЛЭГ

ТӨГСГӨЛИЙН ХЭСЭГ

Хорьдугаар зүйл

Энэхүү Гэрээ арван жил хүчинтэй байна.

Халэлцан Тохирогч Талуудын аль нэг нь энэхүү Гэрээг цуцлах тухай хүсэлтээ тухайн хугацаа дуусахаас зургаан сарын өмнө бичгээр эс мэдэгдвэл дараагийн 10 жил тутамд хүчин төгөлдөр хэвээрээ байна.

Хорин нэгдүгээр зүйл

Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд батламж жуух бичиг солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Батламж жуух бичгийг *Улаанбаатар* хотноо аль болох ойрын хугацаанд солилцоно.

Энэхүү Гэрээг Бээжин хотноо 1968 оны 11 дүгээр сарын 28 өдөр хятад, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд хоёул адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН
ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН
ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ

刘迷卿



**ХЯТАД, МОНГОЛЫН ХИЛИЙН ДЭГЛЭМ, ХИЛИЙН
АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БАЙХ ТУХАЙ БҮГД
НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНДЫН ГЭРЭЭНИЙ
ХАВСРАЛТ ПРОТОКОЛ**

Хятад, Монголын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын хоорондын 1988 оны дүгээр сарын өдрийн Гэрээний заалтыг үндэслэн Хэлэлцэн Тохирогч Талуудын хилийн төлөөлөгчдийн харцуцах хилийн хэсэг, хил нэвтрэх чиглэл, уулзалтын цэг болон хилийн ажилтнуудын хил нэвтрэх үнэмлэх, хил зөрчигч, мал, гэрийн тэжээвэр амьтдыг хүлээлцсэн баримт бичгийн загвар, хилийн тэмдгийг засварласан, сэргээн босгосон, байршилтыг шилжүүлэн босгосон Протоколын загварыг хоёр тал тохиров.

НЭГ. Хоёр талын хилийн төлөөлөгчдийн харцуцах хилийн хэсэг, хил нэвтрэх чиглэл болон уулзалтын цэгийг дор дурдсанаар тогтоов.

А.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас

1. Алтайн хилийн төлөөлөгч

а/харцуцах хэсэг:

Хятад, Монголын хилийн шугамын баруун үзүүрийн эхлэх цэг болох Алтай шань май /Монгол Алтайн нуруу/-ны Хүйтэн шань /Таван богд уул/-н 4104,0 /4050,0/ тоот өндөрлөгөөс эхлэн хилийн 65 дугаар тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 12 дугаар тэмдгээр болон 58 дугаар тэмдгийн баруун талаар

хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд Хуншаньзүй ба Така шикэн-ийн уулзалтын цэгт хүлээн авна.

2.Цонжийн хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Хятад, Монголын хилийн 65 дугаар тэмдгээс хилийн II5 дугаар тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 73 дугаар тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд Улиастайн уулзалтын цэгт хүлээн авна.

3.Хамигийн хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Хятад, Монголын хилийн II5 дугаар тэмдгээс хилийн I84 дүгээр тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн I42 дугаар тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд Лаомяогийн уулзалтын цэгт хүлээн авна.

4.Далай хөвийн хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Хятад, Монголын хилийн 184 дүгээр тэмдгээс хилийн 294 дүгээр тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 218, 236 дугаар тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд Сэхээ, Ганц модны уулзалтын цэгт хүлээн авна.

5.Эрээн хотын хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Хятад, Монголын хилийн 294 дүгээр тэмдгээс хилийн 390 дүгээр тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 326, 357 дугаар тэмдгийн баруун талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд Замын шуран, Эрээн хотын уулзалтын цэгт хүлээн авна.

6.Улиастайн хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Хятад, Монголын хилийн 390 дүгээр тэмдгээс хилийн 536 дугаар тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 407, 452, 493 дугаар тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж,

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд Маргалант, Зүүн хатавч ба Улаанцавны уулзалтын цэгт хүлээн авна.

7. Амгалангийн хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Хятад, Монголын хилийн 536 дугаар тэмдгээс Хятад, Монголын хилийн шугамын зүүн үзүүрийн эцсийн цэг болох 646,7 /645,5/ тоот өндөрлөг бүхий /646,7 /645,0/ тоот өндөрлөг бүхий Тарваган дахын овооны төв /цэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 578, 622 дугаар тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд Өвдөг ба Архашаатын уулзалтын цэгт хүлээн авна.

Б. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талаас

1. Баян-Өлгийн хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Монгол, Хятадын хилийн шугамын баруун үзүүрийн эхлэх цэг болох Монгол Алтайн нуруу /Алтай шань май/-ны Таван Богд уул /Хүйтэн шань/-ын 4104,0 /4050,0/ тоот өндөрлөгөөс эхлэн хилийн 35 дугаар тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 12 дугаар тэмдгээр хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Монгол

Ард Улсын талд Даянгийн уулзалтын цэгт хүлээн авна.

2.Ховдын хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Монгол, Хятадын хилийн 35 дугаар тэмдгээс хилийн 126 дугаар тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 58 дугаар тэмдгийн баруун, хилийн 73 дугаар тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талд Булган, Байтагийн уулзалтын цэгт хүлээн авна.

3.Говь-алтайн хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Монгол, Хятадын хилийн 126 дугаар тэмдгээс хилийн 177 дугаар тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 144 дүгээр тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талд Бургастайн уулзалтын цэгт хүлээн авна.

4.Өмнеговийн хилийн төлөөлөгч

а/хариуцах хэсэг:

Монгол, Хятадын хилийн 177 дугаар тэмдгээс хилийн 294 дүгээр тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 218, 288 дугаар тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талд Шивээ хүрэн, Гашуун сухайтын уулзалтын цэгт хүлээн авна.

5.Дорноговийн хилийн төлөөлөгч

а/хармуцах хэсэг:

Монгол, Хятадын хилийн 294 дүгээр тэмдгээс хилийн 390 дүгээр тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 318 дугаар тэмдгийн зүүн, хилийн 357 дугаар тэмдгийн ба-руун талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талд Ханги, Замын-Үүдийн уулзалтын цэгт хүлээн авна.

6.Сүхбаатарын хилийн төлөөлөгч

а/хармуцах хэсэг:

Монгол, Хятадын хилийн 390 дүгээр тэмдгээс хилийн 536 дугаар тэмдэг хүртэлх хэсэг.

б/уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 413, 452, 499 дүгээр тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талд Асгат, Бичигт, Авдрантын уулзалтын цэгт хүлээн авна.

7. Дорнодын хилийн төлөөлөгч

а/ хариуцах хэсэг:

Монгол, Хятадын хилийн 536 дугаар тэмдгээс Монгол, Хятады хилийн шугамын зүүн үзүүрийн эцсийн цэг болох 646,7 /645,0/ тоот өндөрлөг бүхий Тарваган дахын овоо [646,7 /645,5/ тоот өндөрлөг бүхий цэг] -ны төв хүртэлх хэсэг.

б/ уулзалтын цэг:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн ажилтан нарыг хилийн 578, 622 дугаар тэмдгийн зүүн талаар хил нэвтрүүлж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талд Баянхошуу, Хавиргын уулзалтын цэгт хүлээн авна.

ХОЁР. Хоёр талын хэрэглэх үнэмлэх, баримт бичиг, протоколын загварыг хавсаргав:

а/ хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогч, хилийн төлөөлөгчийн туслагч /уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ болон тэднийг дагалдан яваа ажилтны хил нэвтрэх үнэмлэхийн загвар /хавсралт № 1, 2, 3, 4/;

б/ хил зөрчигч, мал, гэрийн тэжээвэр амьтан болон эд юмсыг хүлээлцсэн баримт бичгийн загвар /хавсралт № 5, 6, 7/;

в/ хилийн тэмдгийг засварласан, сэргээн босгосон, байршилтыг шилжүүлэн босгосон протоколын загвар /хавсралт № 8, 9, 10/.

Энэхүү Протокол Хятад, Монголын хилийн даглам, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын хоорондын Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болно.

Энэхүү Протоколд дурдсан хилийн төлөөлөгчдийн хариуцах хилийн хэсэг, хил нэвтрэх чиглэл, уулзалтын цагийг аль нэг тал нь өөрчилбөл түүнийгээ хилийн төлөөлөгчөөр дамжуулан нөгөө талдаа мэдэгдэх бөгөөд үүнтэй холбогдсон баримт бичигт гарын үсэг зурснаар уг баримт бичиг энэхүү Протоколын бүрэлдэхүүн хэсэг болно.

Энэхүү Протокол, Хятад, Монголын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын хоорондын Гэрээний батламж жуух бичгийг солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Энэхүү Протоколыг 1988 оны 11 дүгээр сарын 28 өдөр Бээжин хотноо хятад, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд хоёр адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН
ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН
ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ

刘迷卿



БНМАУ-ын хилийн төлөөлөгч, түүний
орлогчийн үнэмлэхийн загвар

Ү Н Э М Л Э Х

цээж _____ овогтой
зураг _____ -ыг
_____ /цол, нэр/ _____

БНМАУ-ын _____ хилийн
_____ /харьцах хэсэг/ _____
төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч/-ээр томилов.

Нөхөр _____ нь Монгол, Хятадын
хилийн _____ дугаар тэмдгээс хилийн _____
дугаар тэмдэг хүртэлх хэсэгт хилийн асуудлыг шийдвэр-
лэх эрхтэй бөгөөд хэлэлцэн тохирсон хилийн тэмдгийн
чиглэлээр хил нэвтэрч БНМАУ-ын хилийн _____
_____ -нд очно.
_____ /уулзалтын цэгийн нэр/ _____

БНМАУ-ЫН НАХЯ-НЫ САЙДЫН
ЭРХ ОЛГОСНООР

Тамга _____
_____ /цэргийн цол, овог, нэр/ _____

_____ он _____ сар _____ өдөр

/Хятад хэлээр байна/

Хилийн төлөөлөгчийн туслагчийн
Үнэмлэхийн загвар

Ү Н Э М Л Э Х

цээж _____ овогтой
зураг _____ -н
/цол, нэр/

БНМАУ-ын _____ хилийн
/хэсгийн нэр/ _____
төлөөлөгчийн туслагчаар томиллов.

Нөхөр _____ нь Монгол,
Хятадын хилийн _____ дугаар тэмдгээс
хилийн _____ дугаар тэмдэг хүртэлх
хэсэгт хилийн асуудлыг зохицуулах эрхтэй бөгөөд
хэлэлцэн тохирсон хилийн тэмдгийн чиглэлээр хил
нэвтэрч БНХАУ-ын хилийн _____ -д
очно. /уулзалтын цэгийн нэр/

БНМАУ-ын _____ хилийн
/хэсгийн нэр/ _____
тамга _____
төлөөлөгч _____
/цэргийн цол, овог, нэр/

_____ оны _____ сар _____ өдөр

/Хятад хэлээр байна/

Нарийн бичгийн дарга, орчуулагч,
 мэргэжилтэн нарын үнэмлэхийн
 загвар

Ү Н Э М Л Э Х

цээж
 зураг

----- овогтой
 ----- нь
 /нэр/

БНМАУ-ын ----- хилийн
 /хэсгийн нэр/

төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн
 туслагч/-ийн ----- тул
 хэлэлцэн тохирсон хилийн тэмдгийн чиглэлээр хил
 нэвтэрч БНХАУ-ын хилийн -----
 ----- нд очно. /уулзалтын цагийн нэр/

БНМАУ-ын ----- хилийн
 /хэсгийн нэр/

тамга

төлөөлөгч
 /цэргийн цол, овог, нэр/

----- он ----- сар ----- өдөр

/Хятад хэлээр байна/

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ҮНЭМЛЭХИЙН
ЗАГВАР

Ү Н Э М Л Э Х

цээж
зураг

----- овогтой
----- нь
/нэр/

БНМАУ-ын ----- хилийн
төлөөлөгч /төлөөлөгчийн орлогчийн, төлөөлөгчийн
туслагчийн/-ийн үйлчилгээний ажилтан мөн.

БНМАУ-ын /хэсгийн нэр/ - хилийн

тамга

төлөөлөгч /цэргийн цол, овог, нэр/

----- он ----- сар ----- өдөр

/Хятад хэлээр байна/

Улсын хил зөрчигчийг хүлээлцсэн
саримт бичгийн загвар

/он, сар, өдөр/ ----- №. . . ----- /газрын нэр/ -----
 Монгол, Хятад хоёр улсын хилийг ----- улсаас
 ----- оны ----- сарын ----- өдөр -----
 ----- /хилийн тэмдэг буюу газрын нэр/ ----- зэр зөрчигч
 ----- улсад орж ирсэн -----
 иргэн ----- овогтой ----- /Нэр/ -----
 ----- /хүйс, төрсөн он, сар, өдөр, чац, эрүүл мэндийн байдал, ----- нг
 царайны өнгө, зүс, содон тэмдэг/ -----
 ----- оны ----- дугаар сарын ----- өдөр ----- /хилийн тэмдэг -----
 ----- буюу газрын нэр/ ----- -аар хүлээлцэв.

Уг хүний хамт доорх эд юмсыг хүлээлцэв. Үүнд:

/хүлээлцсэн юмсын онцлог шинж тэмдэг, тоо ширхэг
 болон ямар нэгэн зүйлийг хүлээлцээгүй бол шалт-
 гааныг бичнэ/

----- улсын -----
 хилийн төлөөлөгч /төлөө-
 легчийн орлогч, төлөөлөг-
 чийн туслагч, уулзалтын
 цэгийн дарга, орлогч дарга/

----- /цэргийн цол, овог, нэр -----
 гарын үсэг/

----- улсын -----
 хилийн төлөөлөгч /төлөөлөг-
 чийн орлогч, төлөөлөгчийн
 туслагч, уулзалтын цэгийн
 дарга, орлогч дарга/

----- /цэргийн цол, овог, нэр, -----
 гарын үсэг/

Мал, гэрийн тэжээвэр амьтныг хүлээлцсэн
баримт бичгийн загвар

--- /он, сар, өдөр/ --- №... --- /газрын нэр/ ---

Монгол, Хятад хоёр улсын хилийг --- улсын
нутгаас --- оны --- сарын --- өдөр ---
/хилийн тэмдэг ---

--- буюу газрын нэр/ --- -аар

хил давж --- улсын нутагт орсон ---
тооны --- /мал, гэрийн тэжээвэр амьтан/ --- -ыг

--- /хилийн тэмдэг буюу газрын нэр/ --- -аар
хүлээлцэв.

Түүний дотор ---

/төрөл, зүс, нас, ям тэмдэг, тамга, зрүүл эсэх, бусад
онцлогийг бичнэ/

--- улсын ---
хилийн төлөөлөгч /төлөөлөгч
чийн орлогч, төлөөлөгчийн
туслагч, уулзалтын цэгийн
дарга, орлогч дарга/

/цэргийн цол, овог, нэр,
гарын үсэг/

--- улсын ---
хилийн төлөөлөгч /төлөөлөгч
чийн орлогч, төлөөлөгч
чийн туслагч, уулзалтын
цэгийн дарга, орлогч дарга/

/цэргийн цол, овог, нэр
гарын үсэг/

Эд кмсыг хүлээлцсэн баримт
бичгийн загвар

--- /он, сар, өдөр/ --- №... --- /газрын нэр/ ---

----- улсын хил орчмын нутаг дэвсгэрт
----- оны ----- сарын ----- өдөр олдсон

----- /эд кмсын нэр, тоо, хэлбэр, онцлог/

нь ----- улсынх

болох нь нотлогдсон тул ----- улсын
хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч,
уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/-өөс
улсын ----- хилийн төлөөлөгч /төлөөлөг-
чийн орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга,
орлогч дарга/-д

----- /уг кмны тоо, чанар, байдлыг тодорхой бичнэ/

----- Эд кмыг
хүлээлгэн өгөв.

----- улсын
хилийн төлөөлөгч /төлөөлөг-
чийн орлогч, төлөөлөгчийн
туслагч, уулзалтын цэгийн
дарга, орлогч дарга/

----- /цэргийн цол, овог, нэр,
гарын үсэг/

----- улсын
хилийн төлөөлөгч /төлөөлөг-
чийн орлогч, төлөөлөгчийн
туслагч, уулзалтын цэгийн
дарга, орлогч дарга/

----- /цэргийн цол, овог, нэр,
гарын үсэг/

Хилийн тэмдгийг засварласан
протоколын загвар

ᠮᠣᠨᠭᠣᠯ, ᠰᠠᠷ, ᠥᠳᠡᠷ / - - - - - ᠮ. . . . - - - - - /ᠭᠠᠰᠠᠷᠢᠨ, ᠨᠢᠷ / - - - - -

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хоёр улсын хилийн тухай 1964 оны Протоколын 35 дугаар зүйл, Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хоорондын 1988 оны Гэрээний тавдугаар зүйлийн заалтыг үндэслэн хилийн _____ дугаар тэмдэг /туслах чанарын тэмдэг/ нь _____

шалтгаанаас болж

_____ /ᠡᠪᠳᠡᠷᠰᠢᠨ, ᠪᠠᠶᠳᠡᠯᠢᠮᠤ, ᠪᠢᠴᠢᠬᠡ / _____
 эвдэрснийг хоёр тал газар дээр нь нотлож _____ оны _____
 дугаар сарын _____ өдөр _____ улсын _____
 хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч,
 уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ _____
 улсын _____ хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн
 орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга, орлогч
 дарга/ нар хилийн _____ дугаар тэмдгийг _____

_____ /засвар хийсэн байдлыг тодорхой бичнэ/ _____
 _____ засварлав.

_____ улсын _____
 хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/

_____ улсын _____
 хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/

_____ /цэргийн цол, овог, нэр, гарын үсэг/

_____ /цэргийн цол, овог, нэр, гарын үсэг/

Хилийн тэмдгийг сэргээн босгосон
протоколын загвар

_____/он, сар, өдөр/ _____ № _____/газрын нэр/ _____

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Бүгд
Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хооронд байгуулсан
хоёр улсын хилийн тухай 1964 оны Протоколын 35 дугаар зүйл,
Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх
тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд
Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хоорондын 1988 оны
Гэрээний тавдугаар зүйлийн заалтыг үндэслэн хилийн _____
_____ дугаар тэмдэг /туслах чанарын тэмдэг/ нь _____

_____ /эвдэрсэн байдлыг бичнэ/ _____

_____ шалтгаанаас
болж _____

эвдэрснийг хоёр тал газар дээр нь нотлож _____ оны _____
дугаар сарын _____ өдөр _____ улсын _____
хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч,
уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ _____
улсын _____ хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн
орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга, орлогч
дарга/-ийг байлцуулан уг хилийн тэмдэг /туслах чанарын тэмдэг/-
ийг анх босгосон цэг дээр нь сэргээж, энэхүү тэмдгийн байршил-
тад ямар нэг өөрчлөлт гараагүйг нотлов.

_____ улсын _____
хилийн төлөөлөгч /төлөөлөг-
чийн орлогч, төлөөлөгчийн
туслагч, уулзалтын цэгийн
дарга, орлогч дарга/

_____ улсын _____
хилийн төлөөлөгч /төлөөлөг-
чийн орлогч, төлөөлөгчийн
туслагч, уулзалтын цэгийн
дарга, орлогч дарга/

_____ /цэргийн цол, овог, нэр,
гарын үсэг/ _____

_____ /цэргийн цол, овог, нэр,
гарын үсэг/ _____

Хилийн тэмдгийн байршилтыг шилжүүлэн
босгосон протоколын загвар

— /он, сар, өдөр/ — — — — — №... — /газрын нэр/ — — — — —

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хоёр улсын хилийн тухай 1964 оны Протоколын 35 дугаар зүйл, Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хоорондын 1988 оны Гэрээний тавдугаар зүйлийн заалтыг үндэслэн хилийн _____ дугаар тэмдэг /туслах чанарын тэмдэг/ нь _____ /устсан байдлыг бичнэ/ _____

шалтгаанаас болж устаж үгүй болсныг хоёр тал газар дээр нь нотлож, хилийн _____ дугаар тэмдэг /туслах чанарын тэмдэг/—ийг анх босгосон цэг дээр нь сэргээн босгох нөхцөлгүй болсон тул уг тэмдгийг шинээр үйлдвэрлэн _____ улсын _____ хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ болон _____ улсын _____ хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/ нар _____ /шилжүүлж босгосон газар, зай хэмжээг бичих/ _____
_____ оны _____ дугаар сарын _____ өдөр хамтран босгов.

Хилийн тэмдэг /туслах чанарын тэмдэг/—ийн байршилт болон түүний холбоос болгосон юмсын байршилтыг харуулсан тойм зураг үйлдэж энэхүү Протоколд хавсаргав.

_____ улсын _____
хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/

_____ улсын _____
хилийн төлөөлөгч /төлөөлөгчийн орлогч, төлөөлөгчийн туслагч, уулзалтын цэгийн дарга, орлогч дарга/

— /цэргийн цол, овог, нэр, гарын үсэг/ — — — — —

— /цэргийн цол, овог, нэр, гарын үсэг/ — — — — —